



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ -ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/179/НА-СТА- ОНӨТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Баттогоо Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn Аудитор: Т.Мөнхцацрал Утас: 325093 Цахим хаяг: munkhtsatsralt@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

захирамжаар үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд 999.8 сая төгрөгийг баталсны дагуу нийслэлийн төсвөөс авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Үлдэгдэл	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	751,477,693.48	3,399,200,555.97
1201	Дансны авлага	467,053,200.98	340,241,226.98
1512	Татвар, НДШ-ийн авлага	270,906,466.14	215,537,549.61
1201-05	Бусад авлага	87,586.25	431,897.00
1401	Бараа материал	94,812,551.76	118,035,871.70
1515-01	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	23,879,393.90	36,071,100.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,608,216,892.51	4,109,518,201.26
2001	Үндсэн хөрөнгө	491,641,786.56	671,805,889.42
2101	Биет бус хөрөнгө	11,548,000.00	15,049,466.69
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	503,189,786.56	686,855,356.11
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,111,406,679.07	4,796,373,557.37
3101	Дансны өглөг	203,602,044.30	2,466,507,621.00
3401	Татварын өр	1,296,114.80	4,732,044.80
3101-12	Бусад богино хугацаат өр төлбөр	3,323,473.92	7,647,444.09
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	208,221,633.02	2,478,887,109.89
	Өр төлбөрийн нийт дүн	208,221,633.02	2,478,887,109.89
4101-09	Өмч: - төрийн	161,153,013.31	161,153,013.31
4301-00	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	116,356,098.85
4601-10	Хуримтлагдсан ашиг	1,742,032,032.74	2,039,977,335.32
4601-11	Тайлангийн үеийн ашиг	-	396,148,738.22
	Өмнөх үеийн ашиг	1,742,032,032.74	1,643,828,597.10
	Эздийн өмчийн дүн	1,903,185,046.05	2,317,486,447.48
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,111,406,679.07	4,796,373,557.37

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
5101	Борлуулалтын орлого (цэвэр)	6,117,048,891.89	12,123,177,462.35
61011	Борлуулалтын өртөг	4,310,617,837.13	9,601,972,536.23
	Нийт ашиг(алдагдал)	1,806,431,054.76	2,521,204,926.12
5201-01	Хүүгийн орлого	130,320,653.95	30,654,261.51
5201-06	Бусад орлого	17,020,000.00	400.00
	Орлогын дүн	147,340,653.95	30,654,661.51
71122	Борлуулалт, маркетингийн зардал	234,801,127.28	383,184,058.59
70012	Ерөнхий ба удирдлагын зардал	1,031,108,309.13	1,567,956,265.06
7401-06	Бусад зардал	330,465,409.28	160,399,709.58
	Зардлын дүн	1,596,374,845.69	2,111,540,033.23
5201-02, 7401-02	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(485,369.50)	10,796.66
7401-04	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(181,910.18)	(165,086.37)
	Олз, гарзын дүн	(667,279.68)	(154,289.71)
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	356,729,583.34	440,165,264.69
9101-01	Орлогын татварын зардал	35,672,958.33	44,016,526.47
	Татварын дараах ашиг (алдагдал)	321,056,625.01	396,148,738.22
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	321,056,625.01	396,148,738.22

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	-	1,661,015,911.09	1,822,168,924.40
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(115,047,702.36)	(115,047,702.36)
3	Залруулсан үлдэгдэл	161,153,013.31	-	1,545,968,208.73	1,707,121,222.04
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	321,056,625.01	321,056,625.01
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	(124,992,801.00)	(124,992,801.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	-	1,742,032,032.74	1,903,185,046.05
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(98,203,435.64)	(98,203,435.64)
11	Залруулсан үлдэгдэл	161,153,013.31	-	1,643,828,597.10	1,804,981,610.41
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	396,148,738.22	396,148,738.22
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	116,356,098.85	-	116,356,098.85
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	161,153,013.31	116,356,098.85	2,039,977,335.32	2,317,486,447.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,071,536,835.44	13,635,900,629.31
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,024,362,835.03	12,308,229,925.55
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,184,723.00	10,077,021.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	841,762,900.00	999,859,100.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	203,226,377.41	317,734,582.76
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,813,793,016.54	10,788,832,440.94
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,996,261,331.35	2,821,905,734.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	496,323,074.01	838,971,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	47,322,419.00	272,321,130.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	37,678,380.40	37,678,380.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,230,250.00	30,680,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	13,032,065.42	3,065,426.15
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	297,736,012.24	1,080,223,263.46
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	53,050,000.00	18,294,454.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,867,159,484.12	5,685,693,052.50
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,712,449,778.84)	2,847,068,188.37
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	130,320,653.95	30,654,261.51
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	130,320,653.95	30,654,261.51
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	317,588,697.75	230,014,684.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	306,302,697.75	230,014,684.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,286,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(187,268,043.80)	(199,360,422.49)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	26,609.32
3.1.4	Бусад	-	26,609.32
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	125,478,170.50	11,512.71
3.2.4	Төлсөн ногдол ашиг	124,992,801.00	-
3.2.5	Бусад	485,369.50	11,512.71
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(125,478,170.50)	15,096.61
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,055,002,395.40)	2,647,722,862.49
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,806,480,088.88	751,477,693.48
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	751,477,693.48	3,399,200,555.97

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025.12.31			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого	5,351,809,900.0	7,440,247,400.0	11,244,869,214.7	3,804,621,814.7	151%
Нийслэлийн төсвөөс	765,239,000.0	908,962,800.0	908,962,909.1	109.1	100%
Нийт орлогын дүн	6,117,048,900.0	8,349,210,200.0	12,153,832,123.8	3,804,621,923.8	145%
ББӨ	2,060,637,300.0	2,318,511,500.0	6,571,781,257.1	4,253,269,757.1	283%
Цалин, нэмэгдэл	2,179,927,700.0	3,221,546,300.0	3,157,761,394.3	(63,784,905.6)	98%
Хоол,унаа	323,517,600.0	518,595,000.0	441,984,755.0	(76,610,245.0)	85%
НДШ	326,669,000.0	467,517,700.0	465,335,343.4	(2,182,356.5)	100%
Түрээс, ашиглалт	54,258,200.0	95,079,200.0	78,904,793.8	(16,174,406.1)	83%
Албан томилолтын зардал	122,807,000.0	227,000,000.0	155,411,721.1	(71,588,278.8)	68%
Элэгдлийн зардал	123,120,000.0	139,549,400.0	163,061,519.3	23,512,119.3	117%
Түүхий эд материалын зардал	108,609,400.0	175,644,800.0	170,260,913.3	(5,383,886.6)	97%
Зар сурталчилгааны зардал	78,154,200.0	113,050,000.0	25,531,386.0	(87,518,613.9)	23%
Сургалтын зардал	50,441,300.0	106,069,000.0	38,504,568.1	(67,564,431.9)	36%
Эрдэм шинжилгээ	67,230,800.0	118,580,000.0	96,448,936.2	(22,131,063.7)	81%
Шуудан холбооны зардал	11,088,000.0	15,782,000.0	11,304,640.6	(4,477,359.3)	72%
Тээврийн зардал	29,249,000.0	29,955,600.0	26,121,323.2	(3,834,276.7)	87%
Засварын зардал	65,717,900.0	81,950,000.0	80,310,344.0	(1,639,655.9)	98%
УЗ-н зардал	29,810,000.0	84,510,000.0	46,675,200.0	(37,834,800.0)	55%
Үйл ажиллагааны зардал	5,631,237,400.0	7,713,340,500.0	11,529,398,095.8	3,816,057,595.8	149%
Үйл ажиллагааны бус зардал	129,081,900.0	335,832,000.0	184,268,763.3	(182,217,898.2)	46%
Нийт зардал	5,760,319,300.0	8,049,172,500.0	11,713,666,859.1	3,633,839,697.6	145%
Татвар төлөхийн өмнөх ашиг	356,729,600.0	300,037,700.0	440,165,264.6	140,127,564.6	147%
Татварын зардал	35,672,960.0	126,320,700.0	44,016,526.4	14,012,756.4	35%
Татварын зардал орсон Нийт зардал	5,795,992,260.0	8,175,493,200.0	11,757,683,385.6	3,647,852,454.1	144%
Цэвэр ашиг	321,056,640.00	173,717,000.0	396,148,738.2	126,114,808.2	228%
БОНТНЗ	0.93	0.96	0.96		100%
Авлага	467,053,200.0	366,516,900.0	340,241,226.9	(26,275,673.0)	93%
Өглөг	208,221,600.0	150,321,300.0	2,478,887,109.9	2,328,565,809.8	1649%
Хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр/	342,033,700.0	476,002,300.0	257,638,500.00	(218,363,800.0)	54%
Орон тоо	58	82	62	-20	74%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 91,671.2 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс, 17,082.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 32,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 42,089.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 91,671.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 90,176.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Анхан шатны нотлох баримтгүйгээр 8,921.4 мянган төгрөгийг бараа материалын зардалд зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан 8,921.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2. Цалингийн тооцооллыг хууль журамд нийцүүлэн олгоогүй, цаг бүртгэлийн системийн бүртгэлээс зөрүүтэй 8,160.6 мянган төгрөгийн илүү цаг тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаг бүртгэлийн системийн бүртгэлээс зөрүүтэй илүү цагийн хөлс 8,160.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Тайлант онд 32,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай"-02 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Жолоочийн замын хуудасгүй, тооцоог бодсон актгүй 3,209.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулсан жолоочийн замын хуудас, тооцооллыг хийж ажил гүйлгээг бүртгэж байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-2: Гадаад томилолтын удирдамж, хөтөлбөргүй, нотлох баримт хангалтгүй 20,753.9 мянган төгрөгийн зардал бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гадаад томилолтыг удирдамж, хөтөлбөр, гүйцэтгэсэн ажлын үр дүнг тооцож байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-3: Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг, аж ахуйн материалын зардалд 18,126.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн 05 дугаар албан даалгаврын 1.4-т *тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуусгал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах, 1.4.2-т байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж урамшууллыг түр зогсоох, 1.4.3-д тавилга, эд хогшил, тоног*

төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх”; гэж заасантай тус тус заалтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаг үеийн нөхцөл байдалд тулгуурласан албан даалгавар, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, дотоод зохион байгуулалтыг сайжруулан, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжүүлэхгүйгээр тавилга эд хогшил бэлтгэсэн байна.	1	18,126.2					1	18,126.2				
Цалингийн тооцооллыг хууль журамд нийцүүлэн олгоогүй, цаг бүртгэлийн системийн бүртгэлээс зөрүүтэй, илүү цагийн хуудас нотлох баримт хангалтгүй байхад илүү цаг тооцож олгосон байна.	1	8,160.6	1	8,160.6								
Анхан шатны нотлох баримт хангалтгүй ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч гарсан байна.	1	8,921.4	1	8,921.4								
Тайлант онд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна.	1	32,500.0			1	32,500.0						
Гадаад томилолтын удирдамж, хөтөлбөргүй, нотлох баримт хангалтгүй зардал бүртгэсэн байна.	1	20,753.8					1	20,753.8				
Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан байна.	1	3,209.1					1	3,209.1				
Дүн	6	91,671.1	2	17,082.0	1	32,500.0	3	42,089.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 40 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 160 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Өмнөх оны аудитаар өгсөн "Өндөр насжилттай авлага"-ын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.	1	213,836.6			1	213,836.6		
Нийт дүн	2	213,836.6			1	213,836.6	1	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 05 дугаар сарын 13

№ 144/А0271247

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны нотлох баримт хангалтгүй 8,921,390.00 (найман сая есөн зуун хорин нэгэн мянга гурван зуун ерэн мянга) төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.; заалтад заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Анхан шатны нотлох баримт хангалтгүй 8,921,390.00 (найман сая есөн зуун хорин нэгэн мянга гурван зуун ерэн мянга) төгрөгийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн дарга Р.Амартүвшин, Ерөнхий нягтлан бодогч О.Бямбасүрэн нараар төлүүлж, НТАГ-ын Хүү торгуулийн орлого, Төрийн сан банк МН 440090100200000908 дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн дарга Р.Амартүвшин, Ерөнхий нягтлан бодогч О.Бямбасүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Т.МӨНХЦАЦРАЛ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110277



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 дугаар сарын 13

№ 179/А0291247

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн тооцооллыг хууль журамд нийцүүлэн олгоогүй, цаг бүртгэлийн системийн бүртгэлээс зөрүүтэй, илүү цагийн хуудас нотлох баримт хангалтгүй байхад 8,160,643.00 (найман сая нэг зуун жаран мянга зургаан зуун дөчин гурван мянга) төгрөгийн илүү цаг тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагналыг урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн ТОГТООХ нь:

- Илүү цагийг цаг бүртгэлээс зөрүүтэй тооцож олгосон 8,160,643.00 (найман сая нэг зуун жаран мянга зургаан зуун дөчин гурван мянга) төгрөгийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн дарга Р.Амартүвшин, Ерөнхий нягтлан бодогч О.Бямбасүрэн нараар төлүүлж, НТАГ-ын Хүү торгуулийн орлого, Төрийн сан банк МН 440090100200000908 дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн дарга Р.Амартүвшин, Ерөнхий нягтлан бодогч О.Бямбасүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Т.МӨНХЦАЦРАЛ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110279



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 378/А0271244

Улаанбаатар хот

НТАГ-2026/179/НА-СТА-ОНӨАТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Өндөр насжилттай авлага" 213,826,610.00 (хоёр зуун арван гурван сая найман зуун хорин зургаан мянга зургаан зуун арван) төгрөгийн өмнөх оны шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ", МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаал 1.1-д "Төрийн аудитын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор аудитын явцад алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн дарга Р.Амартүвшин, Ерөнхий нягтлан бодогч О.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Т.МӨНХЦАЦРАЛ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090787



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 333/А0271247

Улаанбаатар хот

НТМ-2026/179/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй 32,500,000.00 (гучин хоёр сая таван зуун мянга) төгрөгийн ажлыг шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ийн дарга Р.Амартүвшин, Ерөнхий нягтлан бодогч О.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Т.МӨНХЦАЦРАЛ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090783